



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

20¹⁷. он
сарын 11 өдөр

Дугаар ЗГ-1/
137

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА М.ЭНХБОЛД ТАНАА

Байнгын хороодтой зөвшилцэх тухай

Монгол Улсын Засгийн газар Азийн хөгжлийн банк хооронд байгуулах "Санхүүжилтийн ерөнхий хөтөлбөр"-ийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн дэмжээд Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороодтой зөвшилцэхээр шийдвэрлэсний дагуу хөтөлбөрийн төслийг холбогдох материалын хамт хүргүүлж байна.

Байнгын хороодын хуралдаанаар хэлэлцүүлж өгнө үү.

Монгол Улсын Ерөнхий сайд



УХҮРЭЛСҮХ


000816

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭС

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 9 дүгээр сарын 27-ны өдрийн хуралдааны 42 дугаар тэмдэглэлд:

"III.ХЭЛЭЛЦСЭН нь: Монгол Улсын Засгийн газар Азийн хөгжлийн банк хооронд байгуулах "Санхүүжилтийн ерөнхий хөтөлбөр"-ийн төслийг хэлэлцээд Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороодтой зөвшилцөхөөр тогтов." гэжээ.

ШИЙДВЭРЛЭСЭН нь: 1. Монгол Улсын Засгийн газар Азийн хөгжлийн банк хооронд байгуулах "Санхүүжилтийн ерөнхий хөтөлбөр"-ийн төслийг хэлэлцээд Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороодтой зөвшилцөхөөр тогтов." гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

ТАНИЛЦУУЛГА

Санхүүжилтийн ерөнхий хөтөлбөрийн тухай

Монгол Улсын Засгийн газар Азийн хөгжлийн банк (АХБ)-тай 2017-2020 онд хамтран ажиллах стратегийг тохирч, санхүү, хөдөө аж ахуй, боловсрол, эрүүл мэнд, хөдөлмөр эрхлэлт, байгаль орчин, нийгмийн салбаруудад хамтран ажиллахаар харилцан тохиролцсон.

Дээрх салбаруудын хүрээнд АХБ-аас 2017-2018 онд Монгол Улсад 468 сая ам.долларын санхүүжилтийн эх үүсвэрийг хуваарилсан бөгөөд үүнээс АХБ-ны Энгийн эх үүсвэрээс 404 сая ам.доллар, АХБ-ны Хөнгөлөлттэй энгийн эх үүсвэрээс 64 сая ам.долларын зээлийн санхүүжилтийг тус тус олгохоор төлөвлөөд байна.

Хөнгөлөлттэй энгийн эх үүсвэрийн зээл нь АХБ-ны хөнгөлөлттэй нөхцөлтэй зээл бөгөөд жилийн 2%-ийн хүүтэй, 25 жилийн хугацаатай, эхний 5 жилд үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөх зээлийн нөхцөлтэй байдаг. Харин энгийн эх үүсвэр¹ийн зээлийн дундаж хугацаа нь 20 жил хүртэл байдаг ба Лондонгийн банк хоорондын хүү дээр нэмэх нь 0.5%-ийн шимтгэлтэй байдаг.

Монгол Улсад хуваарилагдсан зээлийн санхүүжилтээр хэрэгжүүлэх төслүүдийг тодорхойлоходоо эдийн засгийг төрөлжүүлэх, бизнесийн орчинг сайжруулах, нийгмийн хамгааллын салбарын тогтвортой байдлыг хангах, ажлын байр бий болгох зэрэг үндсэн чиглэлийг баримталж, дараах төслүүдийг боловсруулаад байна. Үүнд:

№	Төслийн нэр	Санхүүжилтийн хэмжээ	Энгийн эх үүсвэр	Хөнгөлөлттэй энгийн эх үүсвэр
Хуваарилагдсан зээлийн хөрөнгө				
1	Эдийн засгийн хүндрэлийн үед боловсролын чанар ба хүртээмжийг дэмжих төсөл	50.0	50.0	
2	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүрэх үйлчилгээг сайжруулж, оролцоог нэмэгдүүлэх төсөл	25.0		25.0
3	Бүс нутгийн замыг хөгжүүлэх, зам засварын төсөл	60.0	60.0	
4	Зүүн өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн төслийн нэмэлт санхүүжилт	20.0	20.0	
5	Сэргээгдэх эрчим хүчийг нэмэгдүүлэх төсөл	40.0	40.0	
6	Төсвийн санхүүгийн удирдлагын ил тод, үр ашигтай байдал төсөл	25.0	25.0	
7	Улаанбаатар хотын агаарын чанарыг сайжруулах хөтөлбөр /Бодлогын зээллэг/	130.0	130.0	
8	Тогтвортой аялал жуулчлалыг дэмжих төсөл	38.0	19.0	19.0
9	Улаанбаатар хотын төлбөрийн чадварт нийцсэн орон сууц ба дахин төлөвлөлтийн төсөл	80.0	60.0	20.0
НИЙТ		468.00	404.00	64.00

Мөн, Монгол Улсын Засгийн газар, Олон улсын валютын сан хамтран хэрэгжүүлэх “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-ийн хүрээнд АХБ-тай 2018 онд хоёр үе шаттай

¹ 2012 оноос эхлэн Монгол Улсын зээлжих зэрэглэл ахиж хөнгөлөлттэй нөхцөлтэй зээлээс гадна хундрүүлсэн нөхцөлтэй Энгийн эх үүсвэрээс санхүүжилт авах эрхтэй болсон.

"Улаанбаатар хотын агаарын чанарыг сайжруулах хөтөлбөр" бодлогын зээллэгийг хэрэгжүүлэхээр АХБ-тай идэвхитэй хамтран ажиллаж байна.

Дээрх төслүүдийн зээлийн санхүүжилтийг цаг хугацаанд нь авах, зээлийн хэлэлцээрүүдийг хугацаа алдалгүй АХБ-ны Захирлуудын зөвлөлөөр батлуулах шаардлагатай байгаа тул төслүүдийн зээлийн асуудлаар УИХ-тай нэгтгэсэн байдлаар зөвшилцэж, соёрхон батлуулах зорилгоор Санхүүжилтийн ерөнхий хөтөлбөрийг боловсруулаад байна.

Ингэснээр зээлийн төслийг хэлэлцүүлэн батлуулахад хугацаа алдахгүй ба Засгийн газраас баримталж байгаа бодлогуудад нийцсэн, цаг үеэ олсон төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж эхлүүлэх, холбогдох судалгаа, шинжилгээний ажлыг шуурхай эхлүүлэх зэрэг чухал ач холбогдолтой юм.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

МОНГОЛ УЛС
Болон
АЗИЙН ХӨГЖЛИЙН БАНК (АХБ)
Хоорондын
САНХҮҮЖИЛТИЙН ЕРӨНХИЙ ХӨТӨЛБӨР
ЗЭЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ 2017-2018

ҮҮНЭЭС

(А) Монгол Улс Хамтын ажиллагааны стратеги (2017-2020), Үйл ажиллагааны бизнес төлөвлөгөө (2017-2019)-ний хүрээнд АХБ-аас 2017-2018 онд хөгжлийн төсөл, хөтөлбөрүүдийг санхүүжүүлэх зорилгоор зээлийн санхүүжилт хүсч болно.

(В) Монгол Улс, АХБ ерөнхий хөтөлбөрийг байгуулах хүсэлтэй байгаа бөгөөд энэ хүрээнд Монгол Улс АХБ-ны зээлийн нөхцөлийн дагуу АХБ-аас зээлийн санхүүжилт хүсч болно.

ИЙМД, талууд дараах асуудлыг тохирв.

НЭГДҮГЭЭР ЗҮЙЛ

Хэсэг 1.01 хэсэг. Дор дурдсан Хэсэг 1.02 болон 1.03-т заасны дагуу Монгол Улсын хөгжлийн төсөл, хөтөлбөрүүдийг санхүүжүүлэх зорилгоор АХБ 2017-2018 онд зээлийн санхүүжилт олгож болно. Зээлийн санхүүжилтийн хэмжээ нь дор дурдсан хэмжээнээс хэтрэхгүй байна:

- (a) 2017 онд 135,000,000 (нэг зуун гучин таван сая) ам.доллар, үүнээс 110,000,000 (нэг зуун арван сая) ам.долларыг АХБ-ны энгийн эх үүсвэрээс, үлдсэн санхүүжилт болох 25,000,000 (хорин таван сая) ам.долларыг Хөнгөлөлттэй энгийн эх үүсвэрээс санхүүжүүлж болно; мөн
- (b) 2018 онд 333,000,000 (гурван зуун гучин сая) ам.доллар, үүнээс 294,000,000 (хоёр зуун ерөн дөрвөн сая) ам.долларыг АХБ-ны энгийн эх үүсвэрээс, үлдсэн санхүүжилт болох 39,000,000 (гучин есөн сая) ам.долларыг Хөнгөлөлттэй энгийн эх үүсвэрээс санхүүжүүлж болно.

Хэсэг 1.02. Хөгжлийн төсөл, хөтөлбөр тус бүрийн санхүүжилтийн хэмжээг Монгол Улс, АХБ-тай байгуулах зээлийн хэлэлцээрийн хүрээнд тохирно. Хөгжлийн төсөл, хөтөлбөр тус бурийн тухай мэдээллийг хавсралт 1-д тусгав.

Хэсэг 1.03 АХБ хөгжлийн төсөл, хөтөлбөр тус бурийн санхүүжилтийг Монгол Улсын хүсэлтийн дагуу мөн АХБ-ны Захирлуудын зөвлөлөөр батлагдсаны үндсэн дээр олгоно. Энэхүү Санхүүжилтийн ерөнхий хөтөлбөрийн хүрээнд Монгол Улс нь заавал хэрэгжүүлэх эсхүл АХБ нь заавал зээл олгох үүрэг хүлээхгүй болно.

ХОЁРДУГААР ЗҮЙЛ

Хэсэг 2.01. АХБ-ны Энгийн эх үүсвэрээс олгох зээлийн нөхцөл нь (а) 2017 оны 1 дүгээр сарын 1-ний өдөр батлагдсан АХБ-ны Энгийн үйл ажиллагааны журмын заалтууд, (б) АХБ-ны санхүүжилтийн бодлогууд, (в) холбогдох зээлийн хэлэлцээрүүдэд захирагдана.

Хэсэг 2.02. АХБ-ны Энгийн эх үүсвэрээс олгох хөнгөлөлттэй зээлийн нөхцөл нь (а) 2017 оны 1 дүгээр сарын 1-ний өдөр батлагдсан АХБ-ны Хөнгөлөлттэй энгийн үйл ажиллагааны журмын заалтууд, (б) АХБ-ны санхүүжилтийн бодлогууд, (в) холбогдох зээлийн хэлэлцээрүүдэд захирагдана.

Хэсэг 2.03. Монгол Улс нь АХБ-ны зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөгжлийн төсөл, хөтөлбөрүүдийг АХБ-ны авлигын эсрэг арга хэмжээ, хамгаалал, жендер, худалдан авалт, зөвлөх үйлчилгээ болон зээлийн ашиглалтын бодлогууд мөн холбогдох зээлийн хэлэлцээр болон төслийн баримт бичигт заасны дагуу хэрэгжүүлнэ.

ГУРАВДУГААР ЗҮЙЛ

Хэсэг 3.01. Энэхүү хөтөлбөрийг талуудын ил тод байдлын болон/эсхүл мэдээлэл хүргэх тухай бодлогын дагуу нийтэд ил тод болгож болно.

ДӨРӨВДҮГЭЭР ЗҮЙЛ

Хэсэг 4.01. Энэхүү хөтөлбөр нь гарын үсэг зурсны дараа хүчин төгөлдөр болох бөгөөд 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэл хүчин төгөлдөр байна.

Хэсэг 4.02. Энэхүү хөтөлбөрийн хугацааг талууд бичгээр тохиролцсоны үндсэн дээр сунгаж болно. Талуудын аль нэг Санхүүжилтийн ерөнхий хөтөлбөрийг хүчингүй болгох тохиолдолд нөгөө талтайгаа зөвшилцсөний үндсэн дээр хүчингүй болгоно.

Монгол Улс, Азийн хөгжлийн банк хооронд тохиролцсон дээрх заалтуудыг энд хөрвүүлсэн болно.

Хөтөлбөрийг оны дугаар сарын-ны өдөр Англи хэл дээр 2 хувь байгуулсан ба эх бичвэр бүр нь адил хүчинтэй байна.

МОНГОЛ УЛСЫГ төлөөлж

АЗИЙН ХӨГЖЛИЙН БАНКЫГ төлөөлж

САНГИЙН САЙД

СУУРИН ТӨЛӨӨЛӨГЧ

Хавсралт**Зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрүүд, 2017-2018**

Төслийн нэр	Салбар	Санхүүжилтийн хэмжээ (сая ам.доллар)		
		Энгийн эх үүсвэр	Хөнгөлөлттэй ЗЭҮ	Нийт дүн
2017				
Эдийн засгийн хүндрэлийн үед боловсролын чанар ба хүртээмжийг дэмжих төсөл	Боловсрол	50.0	0.0	50.0
Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүрэх үйлчилгээг сайжруулж, оролцоог нэмэгдүүлэх төсөл	Нийгэм	0.0	25.0	25.0
Бус нутгийн замыг хөгжүүлэх, зам засварын төсөл	Зам тээвэр	60.0	0.0	60.0
2018				
Зүүн өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн төслийн нэмэлт санхүүжилт	Нийтийн аж ахуй	20.0	0.0	20.0
Сэргээгдэх эрчим хүчийг нэмэгдүүлэх төсөл	Эрчим хүч	40.0	0.0	40.0
Төсвийн санхүүгийн удирдлагын ил тод, үр ашигтай байдал төсөл	Санхүү	25.0	0.0	25.0
Улаанбаатар хотын агаарын чанарыг сайжруулах хөтөлбөр /Бодлогын зээллэг/	Санхүү	130.0	0.0	130.0
Тогтвортой аялал жуулчлалыг дэмжих төсөл	Аялал жуулчлал	19.0	19.0	38.0
Улаанбаатар хотын төлбөрийн чадварт нийцсэн орон сууц ба дахин төлөвлөлтийн төсөл	Хот төлөвлөлт	60.0	20.0	80.0
НИЙТ ДҮН		404.0	64.0	468.0

**FRAMEWORK ARRANGEMENT
BETWEEN
ASIAN DEVELOPMENT BANK (ADB)
AND
MONGOLIA
ON
LENDING PLAN IN 2017 - 2018**

WHEREAS

(A) Mongolia may from time to time request ADB to provide lending to finance its development projects and programs in 2017 – 2018 consistent with the Country Partnership Strategy (2017-2020) and Country Operations Business Plan (2017-2019);

(B) Mongolia and ADB wish to establish a framework arrangement within which Mongolia may request for such lending from ADB and the terms and conditions for ADB to provide such lending; and

NOW THEREFORE the parties hereto agree as follows:

ARTICLE I

Section 1.01. Subject to the provisions set out in Sections 1.02 and 1.03 below, ADB may from time to time in 2017 - 2018 provide lending to Mongolia to finance its development projects and programs. The lending amount shall be in an amount not exceeding the equivalent of:

- (a) one hundred thirty five million Dollars (\$135,000,000) in 2017, in which one hundred and ten million Dollars (\$110,000,000) may be financed from ADB's ordinary capital resources and the remaining twenty five million Dollars (\$25,000,000) may be financed from concessional loans from ordinary capital resources; and
- (b) three hundred thirty three million Dollars (\$333,000,000) in 2018, in which two hundred ninety four million Dollars (\$294,000,000) may be financed from ADB's ordinary capital resources and the remaining thirty nine million Dollars (\$39,000,000) may be financed from concessional loans from ordinary capital resources.

Section 1.02. The amount to finance each development project or program shall be as agreed upon in the signed loan agreement between ADB and Mongolia. The details of the development projects and programs are in Appendix 1.

Section 1.03. For each development project or program, ADB shall provide lending only in response to a request by Mongolia and after approval by ADB's Board of Directors. This Framework Arrangement does not constitute an obligation on the part of Mongolia to request or on the part of ADB to approve any lending.

ARTICLE II

Section 2.01. The terms and conditions of ADB lending using ordinary capital resources shall be governed by (a) the provisions of ADB's Ordinary Operations Loan Regulations, dated 1 January 2017; (b) ADB's financing policies; and (c) the relevant loan agreement.

Section 2.02. The terms and conditions of ADB lending using concessional loans from ordinary capital resources shall be governed by (a) the provisions of ADB's Ordinary Operations (Concessional) Loan Regulations, dated 1 January 2017; (b) ADB's financing policies; and (c) the relevant loan agreement.

Section 2.03. Mongolia shall implement the development project or program to be financed through ADB lending in accordance with all applicable ADB policies including those concerning anticorruption measures, safeguards, gender, procurement, consulting services, and disbursement to be described in detail in the relevant loan agreement and other loan documents.

ARTICLE III

Section 3.01. This Agreement may be publicly disclosed by the each of the parties in accordance with their respective policies on disclosure and/or access to information.

ARTICLE IV

Section 4.01. This Framework Arrangement will come into effect on the date of signing and will remain in effect until 31 December 2018.

Section 4.02. This Framework Arrangement may be extended for a further period as may be decided in writing by the Parties. Either Party may terminate this Framework Arrangement in consultation with the other Party.

-End of Clauses -

The foregoing record represents the understandings reached between Mongolia and Asian Development Bank upon the matters referred to therein.

Signed in duplicate at on this day of in the year
Intwo (2) original texts, (...) each in the English language, all texts being equally authentic.

For
MONGOLIA

For
ASIAN DEVELOPMENT BANK

.....

.....

Name:
Designation: MINISTER OF FINANCE

Name:
Designation: COUNTRY DIRECTOR

Date:

Date:

Lending Products, 2017–2018

Project/Program Name	Sector	Cost (\$ million)		
		Regular OCR	COL	Total
2017				
Sustaining Access to and Quality of Education during Economic Difficulties	Education	50.0	0.0	50.0
Ensuring Inclusiveness and Service Delivery for Persons with Disability	Social	0.0	25.0	25.0
Regional Road Development and Maintenance Project	Transport	60.0	0.0	60.0
2018				
Southeast Gobi Urban and Border Town Development Project (Additional Financing)	Water Supply and Other Urban Infrastructure and Services	20.0	0.0	20.0
Upscaling Renewable Energy	Energy	40.0	0.0	40.0
Strengthening ICT Systems for Efficient and Transparent Public Investment and Tax Administration	Public Sector Management	25.0	0.0	25.0
Ulaanbaatar Air Quality Improvement Program (PBL)	Public Sector Management, Transport, Energy	130.0	0.0	130.0
Sustainable Tourism Development	Agriculture, Natural Resources, and Rural Development	19.0	19.0	38.0
Ulaanbaatar Affordable Housing and Urban Renewal Project	Water Supply and Other Urban Infrastructure and Services	60.0	20.0	80.0
Total		404.0	64.0	468.0